



БИЧИЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХ

- Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймаг -

ХҮНИЙ ЭРХИЙН СУДАЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

Нэр томъёоны товчлол

Хүний эрхийн судалгаа, нөлөөллийн ажлын тухай	4
Нэг. Төрийн байгууллага, ХАМО болон бичил уурхайчдын үйл ажиллагаа	6
Хоёр. Сургалт, сурталчилгааны ажлын тухай	18
Гурав. Санал асуулгын дүн	21
Дөрөв. Санал, зөвлөмж	26

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

АМГ

Ашигт малтмалын газар

ЗГ

Засгийн газар

ХАМО

Хувиараа ашигт малтмал олборлогч

ХЭҮК

Хүний эрхийн Үндэсний Комисс

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2012 онд “Монгол Улс дахь бичил уурхай ба хүний эрх” хяналт шалгалтын ажлыг тус төсөлтэй хамтран хэрэгжүүлж, хяналт шалгалтын дүнг 2012 оны 10 дугаар сард зохион байгуулсан “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” олон улсын хурал дээр танилцуулсан билээ.

Харин энэ удаад ХЭҮК Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн санхүүжилтээр зарим аймаг дахь бичил уурхайн салбар дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, нөлөөллийн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах зорилгоор Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймгуудад 2013 оны 6-8 саруудад ажиллалаа.

Судалгаа, нөлөөллийн ажлын хүрээнд дараах асуудлуудад голлон анхаарч ажилласан болно. Үүнд:

1. Орон нутаг дахь төрийн байгууллага, албан тушаалтнуудын бичил уурхайн чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хүрээнд: сумын ИТХ-аас бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлт, түүнийг шийдвэрлэж буй байдлын талаарх болон бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож шийдвэр гаргуулсан газрын талаарх мэдээллийг авах, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргасан шийдвэрээ нийтэд зарлан мэдээлж, хэрэгжилтэд нь хэрхэн хяналт тавьж байгааг шалгах, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн дагуу бичил уурхайгаар ашгт малтмал олборлох иргэдэд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход нь эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж, хууль зүйн зөвлөгөө өгч байгаа байдалтай танилцах, сум, дүүргийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар олгосон газрын зураг зүйн нэгдсэн бүртгэл, олборлолтын мэдээтэй танилцах, гаргуулан авах, бичил уурхай эрхлэгчдэд үзүүлж буй нийгмийн халамжийн арга хэмжээтэй танилцах, бичил уурхай эрхлэгчдийг татвар, даатгалд хамруулах ажлыг хэрхэн зохион байгуулж байгаатай танилцах зэргийг төлөвлөсөн болно.

2. Бичил уурхайтай холбоотойгоор нөхөрлөлөөс явуулж буй үйл ажиллагаатай танилцах ажлын хүрээнд: байгаль орчныг нөхөн сэргээх талаар авч буй арга хэмжээ, хийсэн ажлын тайлантай танилцах, нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг захиран зарцуулж буй байдалтай танилцах ажлыг төлөвлөсөн болно.

3. Бичил уурхай эрхлэгч иргэдийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай танилцах ажлын хүрээнд: Бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон бичил уурхайчид болон ийнхүү зохион байгуулалтад ороогүй байгаа гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн талаар судлах, бичил уурхай эрхлэх насанд хүрээгүй хүүхдүүдийг хөдөлмөрлүүлж байгаа эсэхийг шалгах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрмийг хэрхэн биелүүлж ажиллаж байгаатай танилцах, бичил уурхайн үйл ажиллагаанд химийн хорт болон аюултай бодис ашиглаж байгаа эсэхийг шалгах, бичил уурхай эрхлэгчид нь төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн болон эмнэлгийн үйлчилгээг цаг тухай бүрт нь авч чадаж байгаа эсэхтэй танилцах ажлыг төлөвлөсөн болно.

4. Орон нутаг дахь төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтан, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сургалт сурталчилгаа хийх ажлын хүрээнд: ХЭҮК-ын үйл ажиллагаа, хүний эрхийн ерөнхий ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, бичил уурхайн хууль тогтоомж, түүний онцлог зохицуулалтын сэдвээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлуудыг төлөвлөсөн болно.

Энэхүү судалгаа, мониторингийн ажлыг гүйцэтгэсээр бичил уурхайн хууль тогтоомжийг хүний эрхийн үүднээс боловсронгуй болгох, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулах баримт, мэдээллийг цуглуулах, төрийн байгууллага, албан тушаалтны хүний эрх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзсэн болно.

НЭГ.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХАМО БОЛОН БИЧИЛ УУРХАЙЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Комисс, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн санхүүжилтээр бичил уурхайн үйл ажиллагаа явагддаг Баянхонгор аймгийн Баян-Овоо сум, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Бигэр, Чандмань сум, Ховд аймгийн Алтай, Үенч, Булган, Дөргөн зэрэг 8 сумыг сонгон судалгаа, мониторингийн үйл ажиллагаа явууллаа.

ХЭҮК аймаг, сумдын нутаг дэвсгэрт ажиллахдаа Ашигт малтмалын тухай хууль, ЗГ-ын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хүний эрхийн үүднээс үнэлж дүгнэх, цаашид шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулахыг зорьсон болно.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сум

ХЭҮК Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт 2013 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд ажиллалаа.

Комиссыг тус сумын нутаг дэвсгэрт ажиллах үед аймгийн төвийн “А” зэрэглэлийн бүсэд хүнсний захын ойролцоо мөнгөн ус ашиглаж хууль бус үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлсэн тухай аймгийн Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн мэдээллийг хэлэлцэж, 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдөр аймгийн Онцгой комисс хуралдсан байлаа. Үүнтэй холбоотойгоор мөн өдөр Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Жаргалсайхан 263 дугаар захирамж гаргасан байв.

Уг захирамжид зааснаар хүний эрүүл мэндэд нэн хортой мөнгөн усыг хууль бусаар ашигласан, гар аргаар нууцаар алт олборлож аймгийн төвд оруулж ирсэн зэрэг ноцтой зөрчил илэрснийг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч Д.Ганбаяраар ахлуулан Онцгой байдлын хэлтсийн дарга, Цагдаагийн хэлтсийн дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга зэрэг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор мөнгөн усны хор хөнөөл, тархац, түүнийг ашиглаж буй эзэн холбогдогчдыг тогтоох хүртэл хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн алт олборлох үйл ажиллагааг 14 хоногийн хугацаанд зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг тус аймгийн төрийн зарим байгууллагуудад¹ даалгасан байна.

¹ Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын хэлтэс, Байгаль орчны газарт даалгасан.

ХЭҮК-ын ажлын хэсэг Баян-Овоо сумын засаг дарга Ж.Пүрэвсүрэнтэй хамт бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй нутаг дэвсгэрээр явж, нөхцөл байдалтай танилцан, гар аргаар ашигт малтмал олборлогчидтой уулзалт ярилцлага хийж, судалгааны санал асуулга авах хэлбэрээр ажиллалаа.

Хэдийгээр аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон хугацааны хязгаарлалт дууссан боловч сумын Засаг дарга 2013 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 46 дугаар захирамжаараа гарган нөхөрлөлийн татварыг нөхөн барагдуулах, гишүүдийг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулах хүртэл үйл ажиллагааг нь түр зогсоохоор шийдвэрлэсэн байна.

Сумын Засаг даргын тайлбарласнаар тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүд гэрээ цуцлагдсан талбайд нөхөн сэргээлтийг зааврын дагуу хийж Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах, улмаар орон нутагт тухайн талбайг хүлээлгэн өгөх асуудал хангалтгүй байна.

ХЭҮК-ын ажлын хэсэг тус сумын Цагаан цахирын орчимд бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцсан бөгөөд ашиглагдаж дууссан, нөхөн сэргээлт хийгдэлгүй үлдсэн талбайн нөхцөл байдлыг гэрэл зургаар баримтжуулав.

Нөхцөл байдлыг талууд хэрхэн үнэлж, дүгнэж байгаа нь зөрүүтэй байна. Бичил уурхайчид сумтай гэрээ байгуулан ашигт малтмал олборлож, уг гэрээ дуусгавар болсон, улмаар цаашид сунгагдахгүй болсон хэдий ч ашигласан талбайдаа нөхөн сэргээлт хийлгүй үлдээх явдал газар авсан, нүх, суваг, шуудуугаа бөглөлгүй үлдээснээс болж мал, амьтан төдийгүй хүн ч унаж бэртэх эрсдэл их байгаа талаар сумын Засаг дарга шүүмжлэлтэй хандаж байгаа бол харин бичил уурхайчид уг талбайд ажиллах хугацаа дууссан хэдий ч гэрээг дахин сунгах хүсэлтээ өгсөн, түүнчлэн ухсан нүх, шуудуунаас алт үргэлжлүүлэн олборлох боломжтой гэж тайлбарлаж байв. АМГ-ын даргын 2011 оны 153 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 15 дугаар зүйлд заасанчлан уурхайн



Зураг № 1, 1 Бичил уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлт хийгдээгүй үлдсэн гэх талбай.

ашиглагдсан хоосон орон зайг буцааж булах, хашаа босгох, анхааруулах тэмдэг тавих замаар аюулгүй болгох ёстой бөгөөд сумын Засаг даргын зүгээс дээрх хоосон орон зайг ашиглаж дууссан даруйд нөхөрлөлөөр тэр даруй бөглүүлж байх шаардлага тавьж ажиллах нь зүйтэй байна. Хэдийгээр зарим газруудад нөхөн сэргээлт хийж байгаатай танилцсан ч нөхөн сэргээлт хийгдэлгүй үлдсэн талбай илүү их хувийг эзэлж байгаа гэж Сумын засаг дарга тайлбарлаж байлаа.

Мөн тус сумын Алтан ус, Ташаа зэрэг газруудад нөхөрлөл, гар аргаар ашигт малтмал олборлогчид идэвхитэй ажилладаг хэдий ч мөн адил нөхөн сэргээлтийн үүргээ биелүүлэхгүй байгаа зөрчил ихээр гардаг тухай мэдээлсэн болно. Үүнээс гадна бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа орчны хог хаягдал их, ил задгай бие засдаг, татвар, төлбөр хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн



Зураг №3 Орон нутгийн бичил уурхайчидтай хийсэн уулзалтын үеэр

даатгалыг цаг хугацаанд нь төвлөрүүлэх ажил хангалтгүй байгаа тухай мэдээллийг ХЭҮК авсан болно.

Нэмж тэмдэглэхэд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид дээрх нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдсон 100 га газрыг Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11²-д заасны дагуу бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргасан байна. Ингээд тусгай хэрэгцээнд сонгож авсан талбайд солбилцол тогтоож Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23-т заасны дагуу Ашигт малтмалын газраар дүгнэлт гаргуулжээ. Үүний дагуу нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжүүдийг багийн иргэдийн хурлын саналыг үндэслэн тухайн шалгаруулахаар төлөвлөж байгаа тухай сумын Засаг дарга тайлбарлаж байв.

Уулзалт, ярилцлагад “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” төрийн бус байгууллагын тэргүүн н.Отгонбаатар тэргүүтэй бичил уурхай эрхлэгчид ирж оролцов. Бичил уурхайчдад хамгийн их тулгамдаж буй асуудал бол тэдний техник, тоног төхөөрөмж байдаг талаар тэд ХЭҮК-той санал бодлоо солилцсон болно. АМГ-ын даргын 2011 оны 153 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 40 дүгээр зүйлд “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 500см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизм ашиглахыг хориглоно.” гэж заасан нь ихэнх тохиолдолд бичил далд болон ил уурхайг гар

² Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23 “энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох.”

аргаар явуулахаас өөр аргагүй байдалд хүргэж байна гэж шүүмжилж байлаа. Учир нь хад чулуулаг ихтэй зарим газруудад дээр журамд зааснаас илүү багтаамжтай механизм ажиллуулах шаардлага гардаг талаар санал бодлоо солилцож, уг заалтыг бодит нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй гэж байв.

Тус суманд байгаль орчинд нөлөө үзүүлж буй хэд хэдэн хүчин зүйл байгаа талаар сумын Засаг дарга тайлбарласан ба Баянхонгор аймгийн Галуут сумаас нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүд Баян-Овоо сумын нутгаар дайрч өнгөрдөг учраас байгаль орчинд ихээр хохирол учруулдаг байна. Түүнчлэн нас барсан хүмүүсийг тус сумын нутаг дэвсгэрт ил тавьж зан үйл үйлддэг нь нас барсан хүний сэг зэм, хог хаягдлыг золбин ноход сумын төв рүү авчрах эрсдлийг нэмэгдүүлдэг байна. Мөн бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй иргэд орчин тойрондоо хог хаягдал ихээр үүсгэдэг нь байгаль орчныг бохирдуулах үндсэн шалтгаан болдог байна.

ХЭҮК тус сумын нутаг дэвсгэрт ажиллахдаа гар аргаар ашигт малтмал олборлогч 41 хүнээс судалгааны санал асуулга авсан болно.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум

Комиссын ажлын хэсэг 2013 оны 6 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн төв Алтай хот, мөн Есөнбулаг суманд ажиллаа. Тус суманд бүртгэгдсэн нөхөрлөл үйл ажиллагаа явуулдаггүй байна. Тийм учраас одоогоор бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбилцлыг нь тогтоосон газар байхгүй. Харин сумын төвөөс 3 км-ын зайтай орших газарт хувиараа ашигт малтмал олборлогч иргэд цөөн тоогоор цуглан алт олборлож байгаатай Комиссын төлөөлөл очиж уулзан, судалгааны санал асуулга авсан болно.



Зураг №4 Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд ажиллаж байгаа ХАМО иргэд

Иргэдийн алт олборлож буй газар нь өмнө нь ашиглагдсан бөгөөд нөхөн сэргээлт хийгдээгүй талбай бөгөөд сумын байгаль орчны байцаагчийн тайлбарласнаар уг газарт дунджаар 20-30 иргэн гар аргаар алт олборлож байна.

Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэд санал асуулгад харьцангуй идэвхитэй оролцсон бөгөөд өөрсдөд нь тулгарч буй бэрхшээлийн талаар ажлын хэсэгтэй саналаа солилцсон болно. Тус суманд гар аргаар ашигт малтмал олборлож буй цөөн тооны ХАМО иргэдийг зохион байгуулалтад оруулж, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 3.1 дэх хэсэгт заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас шийдвэр

гаргаж, улмаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг бүртгэгдээгүй 2-3 нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах бүрэн боломжтой байгаа нь Комиссыг тус суманд ажиллах үед тогтоогдсон болно.



Зураг №5 Судалгааны санал асуулгад оролцож буй ХАМО иргэн

Есөнбулаг суманд үйл ажиллагаа явуулж буй ХАМО иргэд нь байнгын ажилгүй залуу гэр бүлүүд, тэтгэвэрт гарсан хөгшин настай хүмүүс байна. Олборлож буй алтны хэмжээ харьцангуй бага бөгөөд өдөрт дунджаар 10-15 мянган төгрөгийн алтыг нэг хүн олборлодог тухай хэлж байв. Сумын хэмжээнд өмнө нь бичил уурхайн зориулалтаар олгосон газрын зураг зүйн нэгдсэн бүртгэл, олборлолтын мэдээ хөтлөгддөггүй байна.

Комисс сумын төвөөс 4 км орчим зайд байрлах алтны судал бүхий ашиглагдсан талбайд ажиллаж буй ХАМО иргэдээс судалгааны санал асуулга авсан бөгөөд 21 хүн санал асуулгад оролцов.

Говь-Алтай аймгийн Бигэр сум

Комисс Бигэр суманд 2013 оны 6 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд ажиллаа.

Энэ үеэр сумын Засаг дарга томилолтоор багуудад ажиллахаар явсан байсан ба сумын Засаг даргын орлогч болон сумын Иргэдийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нартай ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг уулзалт хийж, тус сум дахь хувиараа ашигт малтмал олборлогчдын нөхцөл байдлын талаарх мэдээллийг авсан болно. Тус суманд хувиараа алт олборлогчдын ажиллаж буй газар нь алтны шороон ордын үлдэгдэл ба тоос ихтэй, агааргүй орчинд хөдөлмөрийн хамгийн хүнд нөхцөлд, эрсдэлтэй ажил эрхэлдэг тухай мэдээлсэн болно.

Тус суманд алтны гарц бусад газруудтай харьцуулахад харьцангуй өндөр байх үед хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн тоо даруй 45000-д хүрч байсан хэдий ч өнөөдрийн байдлаар тогтмол, идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй хувиараа ашигт малтмал олборлогч иргэд эрс цөөрсөн байна. Түүнчлэн тус суманд хувиараа алт олборлогчдын талаар нэгдсэн бүртгэл тоо баримт байхгүй байв.

Комисс Бигэр суманд бичил уурхайгаар үйл ажиллагаа эрхэлдэг, алт хамгийн их олборлодог Сэрхийн нуруу гэх газарт 2-3 уулын аманд очиж үзэхэд цөөн тооны хүмүүс майхан, сав бэлтгэн газар ухаж байв. Сэрхийн нуруунд иргэд алтны гарц бүхий хэд хэдэн аманд өмнө нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байсан ч одоо багассан байна. Эдгээр

амуудад нийлээд 11 хүн байсан ба тэдгээр иргэдээс судалгааны санал асуулга авсан болно. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутаг, бусад хот суурин газруудаас хүмүүс алтны нөөц бүхий газар руу ирж ажиллах болсон бөгөөд тус суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөл байхгүй байв. Комиссын судалгаанд хамрагдсан 11 хүний 8 нь Баянхонгор аймгаас ирсэн хувиараа ашигт малтмал олборлогч иргэд байсан болно.

ХАМО иргэд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны наад захын дүрэм журмын талаарх мэдлэг, ойлголт байхгүй, зөвхөн нүх ухаж, түүнийгээ шигших багаж төхөөрөмжийг хэрхэн ажиллуулдаг талаар л ойлголттой байв.

Комиссын баг Сэрхийн нуруунд очих үед хэд хэдэн газар нүх ухсан байсан бөгөөд зарим газарт өмнө ашиглаад булсан хөрсийг дахин ухаж нүх гаргасан байсан ба энэ нь нурах, хөрс шорооны гулсалт явагдах эрсдэлтэй байдалд байлаа.

Говь-Алтай аймгийн Чандмань сум

Комиссын ажлын хэсэг Чандмань суманд 2013 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд ажиллаа. Чандмань сумын төвөөс 60 орчим км-ын зайтай орших Хөх сайр гэх газарт гар аргаар ашигт малтмал олборлогчид үйл ажиллагаа идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.



Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил

Зураг №6 Чандмань сумын нутаг дэвсгэр Хөх сайр гэх газар

үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу бичил уурхай эрхлэгч нь сар тутам 53000 төгрөгийн орлогын албан татварыг төлөх үүрэгтэй бөгөөд бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй өвлийн улиралд, мөн олборлолт бага байх тохиолдолд дээрх татварыг төлөхөд хүндрэлтэй байдаг тухай тус сумын нутагт алт олборлож буй иргэд олонтаа хэлж байв. Түүнээс гадна олборлосон алтаа хэрхэн худалдан борлуулдаг тухай тодруулахад бүгд ченжүүдэд худалддаг гэсэн хариулт хэлж байлаа. Үүнд нэгдүгээрт, тэд албан ёсны бичил уурхай болж зохион байгуулагдаагүй байгаа нь, хоёрдугаарт, ихэнх нь ченжүүдэд өр, төлбөртэй байдаг тул олсон алтаа өрөндөө өгөх тохиолдол түгээмэл байна. Цаашид хөдөө орон нутагт албан ёсны бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн олборлосон ашигт малтмалыг худалдаж авах тогтолцоог төлөвшүүлэх шаардлага тулгамдаж байна.

Түүнчлэн Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 153 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-

ийн 6 дугаар зүйлийн 40-д зааснаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизм ашиглахыг хориглосон ба тус сумын нутагт гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэд үүнээс дээш багтаамжтай машин механизмыг ашигладаг ба журмын энэхүү шаардлагыг хангаж чаддаггүй байна.

Дээрх шалтгааны улмаас бие даасан нөхөрлөл байгуулж, журамд заасны дагуу бичил уурхайн зохион байгуулалтад ороход хүндрэлтэй байдгаа Комиссын ажлын хэсгийнхэнд тайлбарласан юм.

Үүнээс гадна орчны хог хаягдал их, эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй нь тэнд ажиллаж, амьдарч буй иргэдийн эрүүл орчинд амьдрах эрхэд ноцтой нөлөө үзүүлж байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхцөлд тухайн нөхөрлөл нь орчны тохижилт хийх, хог хаягдлын цэг байгуулах үүрэг хүлээж ажилладаг ч энд байгаа ХАМО иргэдийн хувьд энэ маягаар зохион байгуулалтад ороогүй тул хяналт тавих боломжгүй байна.

Комисс 18 хүнээс санал асуулга авч судалгааны материалд хавсаргав.

Ховд аймгийн Алтай сум

Комиссын ажлын хэсэг Ховд аймгийн Алтай сумын нутагт 2013 оны 8 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд ажиллалаа.

Тус сумын нутаг дэвсгэрт одоогоор ямар нэгэн бичил уурхайн үйл ажиллагаа явагдаагүй байна. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар тогтоосон газар байхгүй байна.



Зураг №7 Бичил уурхайн улмаас эвдрэлд орсон газар

Харин сумын төвөөс 110 км-ын зайд орших дархан цаазат газарт бичил уурхайн олборлолт явуулсны улмаас тухайн газар нутаг нэлээдгүй эвдэрсэн бөгөөд тус газрыг нутгийн иргэдийн дэмжлэгтэйгээр шороогоор булж нөхөн сэргээлт хийсэн талаар сумын Засаг дарга тайлбарласан болно.

ХЭҮК-ын ажлын хэсэг тус сумын Бодонч, Барлаг, Тахилт багуудын нутаг дэвсгэрээр ажиглалт хийсэн ба ХАМО иргэдийн үйл ажиллагаатай танилцахыг зорьсон хэдий ч эдгээр багуудад ямар нэгэн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа иргэдтэй тааралдаагүй болно.

Сумын ИТХ-ын 2013 оны 2 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Ховд аймгийн Алтай сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” (2012-2016)-ийн 4.24-т хууль бусаар алт олборлолтыг зогсоож бичил уурхай эрхлэх нөхөрлөл байгуулах үйл ажиллагааг дэмжинэ.” гэж заасныг энд дурдая.

Ховд аймгийн Үенч сум

Комиссын ажлын хэсэг Ховд аймгийн Үенч сумын нутагт 2013 оны 8 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд ажиллалаа.

Тус сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын 26 тусгай зөвшөөрөл бүхий алтны орд газар байдаг байна. Тухайн ашигт малтмалын хайгуулын лиценз нь голын ай, сав газарт олгогдсон байдаг учраас тус лиценз бүхий газруудыг төрийн тусгай хамгаалалтад авсан байна. Хар чулуутын ам гэх газарт алтны илэрц гарч байх үед иргэд нөхөрлөл байгуулах тухай санал хүсэлтээ гаргаж байсан боловч уг газрыг улсын хамгаалалтад авсан учраас бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоосон байна. Тухайн бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газарт ямар нэгэн нөхөн сэргээлт хийгдээгүй байна. Одоогоор тус сумын нутаг дэвсгэрт ямар бичил уурхайн үйл ажиллагаа явагдаагүй байна.

Тус сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын 26 лизенц бүхий алтны орд газар байдаг байна. Тухайн ашигт малтмалын хайгуулын лиценз нь голын ай, сав газарт олгогдсон байдаг учраас тус лиценз бүхий газруудыг төрийн тусгай хамгаалалтад авсан байна. Хар чулуутын ам гэх газарт алтны илэрц гарах үед иргэд нөхөрлөл байгуулах тухай саналаа гаргаж байсан боловч уг газрыг улсын хамгаалалтад авсан учраас бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болж зогсоосон байна. Уг бичил уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газарт ямар нэгэн нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

Ховд аймгийн Булган сум

Комисс Ховд аймгийн Булган сумын нутагт 2013 оны 8 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд бичил уурхайн үйл ажиллагаатай танилцаж, нөлөөллийн ажлыг явууллаа.

Тус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2007 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Ховд аймгийн Булган суманд бүртгэлтэй зөвхөн 18 насанд хүрсэн иргэнийг “Цоохор нуур” гэх газрын 4 га талбайд гар аргаар ашигт малтмал олборлохыг зөвшөөрсөн тогтоол гарсан байна. Түүнээс хойш одоог болтол тус сумаас 10 километрийн зайд орших “Цоохор нуур” гэх газарт 7 бүртгэгдээгүй нөхөрлөл бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байна. Нэг нөхөрлөл ойролцоогоор 5-12 гишүүдтэй байна.

Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын холбогдох заалтыг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 153 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай” гэрээний загварыг,



хоёрдугаар хавсралтаар

Зураг №8 ХАМО иргэдийн үйл ажиллагаа

“Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ”-ны загварыг, 3 дугаар хавсралтаар “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн заавар”-ыг, 4 дүгээр хавсралтаар Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаархи мэдээллийн маягт”-ыг ... зэргийг тус тус баталсан байна.



Зураг №9 ХАМО иргэдийн үйл ажиллагаа

Тус сумын засаг дарга нөхөрлөлийн гишүүдтэй Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын (АМГТХЭГ) 2008 оны 149 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт буюу Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн хамтран ажиллах гэрээг 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр нэг жилийн хугацаатай байгуулж, уг гэрээндээ нөхөрлөлийн гишүүн бүр нийгмийн даатгалын шимтгэлд (тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал) 16848 төгрөг, эрүүл мэндийн даатгалд 670 төгрөг, орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварт 53 000 төгрөгийг төлж тухайн хураамжийг дундын мөнгөн хөрөнгийн санд оруулах зэрэг нөхцлийг тусгажээ. Гэтэл дээрх АМГТХЭГ-ын даргын 2008 оны 149 дүгээр тушаалыг Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 153 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна. Өөрөөр хэлбэл тус сумын засаг дарга бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй нөхөрлөлтэй хүчингүй болсон тушаалын

хавсралтаар батлагдсан гэрээний загвараар 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр гэрээ байгуулжээ.

Мөн тухайн газарт бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлийн гишүүдээс татвар, хураамж авч чаддаггүй талаар сумын Засаг даргын тамгын газрын дарга ажлын хэсгийнхэнд тайлбарлаж байсан болно. Өмнө нь зарим нэг аж ахуйн нэгж, компаниуд алтны орд ашиглаж байсан хэдий ч эдгээр компаниудтай гурвалсан гэрээ байгуулах талаар яриа хэлэлцээр хийж үзээд амжилт олж байгаагүй байна. Учир нь тодорхой нэг алтны ордны тогтоогдсон нөөцөөс нь ХАМО иргэд ашигласнаар компанид ямар нэгэн ашиг байхгүй, харин ч алдагдалтай ажиллах болдог тул гурвалсан гэрээ байгуулах тал дээр хойрго хандаж байжээ. Эндээс үзвэл, гурвалсан гэрээ байгуулж өөрсдийн талбай дээр бичил уурхайчдыг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, компаниудыг урамшуулах тогтолцоог бий болгож болох юм гэсэн дүгнэлт хийж байна.

Одоогоор тухайн бичил уурхайн олборлолт хийсэн талбайд нөхөн сэргээлт огт хийгдээгүй байна. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д заасны дагуу нөхөрлөл талбайг буцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зааврын дагуу хийж, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сумын Засаг даргын томилсон Комисст хүлээлгэн өгөх ёстой ч энэ ажил хангалтгүй байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдтэй Комиссын төлөөлөл газар дээр нь очиж танилцсан ба биднийг очих үед бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийн дийлэнх нь хадлангаа хураахаар явсан байсан тул тухайн үед тэнд ажиллаж байсан 14-46 насны (эрэгтэй 9, эмэгтэй 3) нийт 12 хүнээс судалгааны санал асуулга авсан болно. Тухайн газрын нөхцөл байдлыг фото зургаар баримтжуулав.

Ховд аймгийн Дөргөн сум

Комиссын ажлын хэсэг Ховд аймгийн Дөргөн сумын нутагт 2013 оны 8 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд бичил уурхайн үйл ажиллагаатай танилцаж, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Тус сумаас 10 км-ын зайд орших Аргалант багийн нутаг дэвсгэр Хөх эрэг гэх газарт 2012 оны 11 сараас иргэд хууль бусаар алт олборлож эхэлсэн байна. Тэр үеэс сумын удирдлагууд хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож чадахгүй байсаар одоог хүрсэн бөгөөд Засгийн газрын 308 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нутгийн иргэдийг хуулийн хүрээнд зохион байгуулалтад оруулан бичил уурхайн зориулалтаар олборлолт явуулах нөхцөл бүрдүүлэхээр холбогдох байгууллагад уламжилсан боловч өнөөдрийг хүртэлх хугацаанд хууль огт шийдэгдэхгүй байгаа талаар сумын засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар танилцуулсан болно.

Засгийн газрын 308 дугаар тогтоолын дагуу ард иргэдэд хуулийн мэдээлэл өгч зохион байгуулалтад оруулж 43 жижиг нөхөрлөл бүхий “Өнгөт” нэртэй иргэдийн бүртгэгдээгүй толгой нөхөрлөлийг байгуулахад нь сумын Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлсэн байна.



Одоогоор хуулийн дагуу албан ёсны зөвшөөрөл олгогдоогүй учир иргэд хууль бусаар алт олборлосоор байна. Тухайн бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүмүүс хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа учир ямар нэгэн зохион байгуулалтад ороогүй, нийгмийн халамж, даатгалд хамрагдаагүй, татвар төлөхгүй, ямар нэгэн хуримтлал бий болгоогүй байна.



Тус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор Аргалант багийн Хөх эрэг гэх газарт ойролцоогоор 5 га газрыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар шийдвэрлэж, бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбилцлыг тогтоосон газрыг Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар Ашигт малтмалын газарт хүсэлт гаргасан байна.

Зураг №10, 11 Дөргөн сумын нутагт ажиллаж, амьдарч буй бичил уурхайчид хиймэл нуур үүсгэн усыг алт угаах ажилд ашиглаж байгаа нь

Ашигт малтмалын газраас дээрх хүсэлтийг хянаж үзээд 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Засгийн газрын 2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 86 тоот тогтоолын а-д улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан 2 дугаар хавсралтад заасан талбайн геологийн судалгааны дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий газарт Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.12-т зааснаар сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулж, явцад нь байнгын хяналт тавьж ажиллахаар заасны дагуу дээрх хүсэлт гаргасан талбай нь 86 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын жагсаалтад багтаж байгаа учраас дүгнэлт гаргах боломжгүй.” гэсэн хариуг өгсөн байна.

Тус сумын Хөх эрэг гэх дээрх газарт хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдтэй газар дээр нь уулзаж, нийт 16-60 насны (эрэгтэй 53, эмэгтэй 12), нийт 69 хүнээс судалгааны санал асуулга авсан болно.

ХЭҮК-ын сонгон авсан сумд нь бүгд алт олборлож байгаа бүс нутгууд бөгөөд эрдсийн гаралтай буюу жонш, нүүр зэрэг ашигт малтмал олборлож байгаа гэх ХАМО иргэд, бичил уурхайчидтай тааралдаагүй болно.



ХОЁР. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5-д заасны дагуу хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих явдал нь Комиссын үндсэн чиг үүргийн нэг билээ. Комисс “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага” зэрэг сургалтын модулиудыг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд энэхүү нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд бичил уурхайн болон ХАМО иргэд үйл ажиллагаа явуулдаг бүс нутгуудад хүний эрхийн сургалт, сурталчилгааны ажлыг давхар хийсэн бөгөөд сургалтын ажлын цар хүрээг хүснэгтээр үзүүлбэл доорхи байдалтай байна.

Очсон газар	Сургалтад хамрагдсан хүн	Тараасан ном товхимлын тоо	Тараасан танилцуулга, брошурын тоо
Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	47	49	63
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум	32	32	65
Говь-Алтай аймгийн Бигэр сум	43	43	56
Говь-Алтай аймгийн Чандмань сум	27	31	21
Ховд аймгийн Булган сум	16	12	23
Ховд аймгийн Дөргөн сум	21	21	26
Нийт	186	188	254

Зарим газар сургалтын байр танхим хангалтгүй, оролцогчдын идэвхи сул байсан бөгөөд иргэнд Засаг даргын тараасан зар мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар ирж сургалтад суухгүй байв. Харин орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчдад хийсэн сургалтад харьцангуй олон хүн хамрагдсан бөгөөд сургалтын үед сургагч багшаас олон төрлийн асуулт асууж, мэдлэг ойлголтоо дээшлүүлэх сонирхолтой байгаа нь харагдаж байв.

Комисс 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчидтай тус аймгийн Цагдаагийн газрын хурлын байранд уулзаж, хүний эрхийн ерөнхий ойлголтын талаар сургалт хийсэн болно.

Харин Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдөр



Зураг №12 Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын байранд “Хүний эрхийн ерөнхий ойлголт” сэдвээр сургалт хийж байгаа нь

төрийн албан хаагчдад сургалт хийсэн болно.

Уг сургалтад 32 хүн оролцож, хүний эрхийн ерөнхий ойлголт, хандлагын талаар мэдлэг, ойлголт авлаа.

Комисс Бигэр суманд 2013 оны 6 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд ажиллаа. Комиссын сургалт, сурталчилгааны хэлтэс тус сумын орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн байгууллагын албан хаагчдад “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр тус бүр 1 цагийн сургалт орсон бөгөөд уг сургалтад нийт 43 хүн хамрагдав.

Комиссын ажлын хэсэг Чандмань суманд 2013 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд ажилах үед Комиссын сургалт, сурталчилгааны хэлтэс тус сумын орон нутгийн өөрөө

удирдах байгууллага, төрийн байгууллагын албан хаагчдад “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхийн үндэсний Комиссын үйл ажиллагаа” сэдвээр тус бүр 1 цагийн сургалт орсон бөгөөд уг сургалтад нийт 27 хүн хамрагдав.

Комиссын ажлын хэсэг Ховд аймгийн Булган сумын нутагт ажиллахдаа 2013 оны 08 дугаар сарын 22-ны өдөр “Хүний эрхийн ерөнхий ойлголт” сэдвээр 1 цагийн



Зураг №13 Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын байранд “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр сургалт хийж байгаа нь



Зураг №14 Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын байранд “Хүний эрхийн ерөнхий ойлголт” сэдвээр сургалт хийж байгаа нь



сургалтыг 16 хүнд орсон ба уг сургалтын Ховд аймгийн Дөргөн суманд 08 дугаар сарын 26-ны өдөр хийлээ. Комиссын ажилтнуудын зохион байгуулсан “Хүний эрхийн ерөнхий ойлголт” сэдэвт хичээлд 21 хүн хамрагдав.

Комисс уг сургалтуудаар хүний эрхийн зарчмууд, хүний эрхийн зөрчил, төрийн хүлээх үүрэг, хүний эрхийн хязгаарлалт, хариуцлага, хүний эрхийг хамгаалахад тулгардаг бэрхшээл, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ бодитой, хүртээмжтэй, нийцтэй, чанартай байх талаар, ХЭҮК-т өргөдөл, гомдол хэрхэн шийдвэрлэдэг тухай, мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийн талаарх ойлголтуудыг өгөхийг зорьж ажиллаа.

Оролцогчдын зүгээс хүний эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар, эрхээ зөрчүүлэхгүй байх талаар, төрийн байгууллагын мэдээллийг иргэдэд ямар арга замаар түгээвэл зохих талаар болон ХЭҮК-т гомдол гаргах тохиолдолд тухайн гомдлыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэдэг талаар голчлон асуулт асууж байв. Цаашид сум, орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг цэгцтэй болгох, хамрах хүрээг нэмэгдүүлж чадсан тохиолдолд төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх хандлагад эерэг өөрчлөлт гарах боломж ажиглагдаж байв.

Сургалтад оролцогчдод “Бизнес ба хүний эрх”, “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “ХЭҮК-т гомдол гаргах нь” сэдвээр гаргасан брошур, Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн хэвлүүлдэг “Хүний эрх” сэтгүүлийн сүүлийн 2 дугаар болон Хүний эрхийн мэдээлэл сэтгүүлүүдийг тараасан болно. Мөн сумын Засаг дарга нарт “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” олон улсын хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, тус хурлаас гаргасан зөвлөмж, ХЭҮК-ын 12 дахь илтгэл болон Монгол Улсын Засгийн газарт НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжүүдийн эмхэтгэл номыг тараав.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН


ДӨРӨВ. САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Комиссын судалгаанд нийт 172 хүн оролцож, бичил уурхайн үйл ажиллагааны талаарх сэтгэгдлээ хуваалцсан байна.


Эдгээрийг ажилласан орон нутгийн харьяаллаар харуулбал,

Баянхонгор аймгийн Баян-Овоо сум -	41
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум -	21
Говь-Алтай аймгийн Чандмань сум -	18
Говь-Алтай аймгийн Бигэр сум -	11
Ховд аймгийн Булган сум -	12
Ховд аймгийн Дөргөн сум -	69

1. Комиссын судалгааны ерөнхий асуултын хүрээнд тодруулсан зүйлсээс танилцуулбал: Эрэгтэй 120 /69.8%/, эмэгтэй 43 /25.0%/ хүн оролцсон ба 9 хүн ямар нэгэн хариулт өгөөгүй байна.



Судалгаанд оролцогчдын боловсролын байдалд дүн шинжилгээ хийж үзвэл дараах дүн гарч байна.



Нийт судалгаанд хамрагдагсдын 43.6 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байгаа бөгөөд дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 12.2 хувь байна. Бичил уурхайгаар

болон гар аргаар ашигт малтмал олборлогчид нь ихэнхдээ тухайн орон нутагтаа удаан хугацаанд амьдарч буй иргэд байгаа бөгөөд судалгаанд оролцогсдын 15.1 хувь нь тухайн орон нутагтаа өөр газраас шилжин ирэгсэд байна.

Бичил уурхай эрхлэгчид болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын дунд тухайн орон нутагтаа иргэний бүртгэлд хамрагдах байдал хангалтгүй байгаа нь санал асуулгаас харагдаж байна. Нийт 41 /23.8%/ хүн иргэний бүртгэлд хамрагдсан гэж хариулсан бол үлдсэн хэсэг нь асуултад хариулаагүй, эсвэл иргэний бүртгэлд хамрагдаагүй гэсэн хариултыг сонгожээ.

2. Нөхөрлөлд гишүүнээр элссэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй иргэдээс тусгайлан авсан санал асуулга авахдаа юуны өмнө нэг нөхөрлөл дунджаар хэдэн гишүүнтэй байгааг тодруулсан болно.

Энэхүү санал асуулгад нөхөрлөлд гишүүнээр элссэн 58 хүн оролцлоо.

Санал асуулгад оролцогчдын 63.7 хувь нь буюу 37 хүн өөрийнх нь харьяалагддаг нөхөрлөл 5-10 гишүүнтэй гэж хариулсан бол, 20.6 хувь нь буюу 12 хүн 11-20 хүнтэй гэж хариулсан болно. Мөн 13.7 хувь нь буюу 8 хүн 20-50 гишүүнтэй гэж хариулсан байна. Эдгээр иргэдийн 37.9 хувь нь тухайн нөхөрлөлдөө гишүүнээр элсээд нэг жил болоогүй байгаа хүмүүс байсан бол 17.2 хувь буюу 10 хүн 1-2 жил болж байгаа хүн байв. Мөн 2 жилээс дээш хугацаанд нөхөрлөлийн гишүүнчлэлтэй байгаа 15 хүн буюу судалгаанд оролцогчдын 25.8 хувийг эзэлж байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй иргэдийн үнэмлэхүй олонхи нь буюу 50 хүн /86.2 хувь/ орлогын албан татвараа тогтмол төлж байна хэмээн хариулсан байна. Харин орлогын албан татвараа тогтмол төлж чаддаггүй гэсэн асуултыг сонгосон хүмүүсээс нөхцөл байдлыг тодруулахад, цаашдаа төлөх бодолтой байгаа гэвч орлого тогтмол биш учраас хүндрэлтэй байдаг гэсэн тайлбарыг хийж байсан болно. Үндсэндээ тухайн сард 530 000 төгрөгөөс доош орлого олох нэг хэсэг байхад түүнээс дээш хэмжээний орлого олдог нөгөө нэг хэсэг ч байна. Гэтэл бүгд адилхан 53 000 төгрөгийн татварыг сар бүр төлөх нь ялгавартай байдал үүсгэж байна гэж үзэх хүмүүс ч байлаа.


Судалгаанд оролцсон 58 хүний 56 нь ашигт малтмал олборлосон талбайдаа нөхөн сэргээлтийг хийдэг гэсэн хариултыг өгсөн болно.

3. Нөхөрлөлд гишүүнээр элсээгүй хэдий ч гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдээс авсан санал асуулгын тухайд:

1 жил хүртэл хугацаанд ийнхүү алт ухаж байгаа гэх 56 иргэн байсан бол, 2-3 жил гэж 35, 4-5 жил гэж 11, 6-аас дээш жил гэж 19 хүн хариулсан байна.

Яагаад нөхөрлөлд өнөөдрийг хүртэл элсээгүй байгааг тодруулахад, нөхөрлөлийн талаарх ойлголт, мэдээлэл байхгүй гэж 47 хүн хариулсан болно. Харин 19 хүн нөхөрлөлийн гишүүнээр элсэх шаардлага байхгүй гэж хариулсан бол, нөхөрлөлд элсэх хүсэлтэй ч эслүүлдэггүй гэх хариултыг 5 хүн сонгосон байна. Харин 16 хүн тухайн сум, орон нутагт нь нөхөрлөл байдаггүй гэх хариултыг өгчээ.

Эдгээр иргэдээс авсан судалгаанаас үзэхэд гар аргаар ашигт малтмал олборлосноор ахуй амьдрал нь дээшилсэн гэж 80 хүн буюу 46.5 хувь нь хариулсан бол, хэвэндээ байна гэж 45 хүн буюу 26.2 хувь нь хариулжээ.




Гар аргаар ашигт малтмал олборлогчдын дунд бага насны хүүхэд тухайн ажилд дайчлагддаг байдал байсаар байна. Комисс сонгон авсан бүс нутгуудад ажиллах үед бага насны хүүхдүүд алт угаах, шороо ухах ажилд оролцож байгаатай тааралдсан бөгөөд судалгааны дүнгээс үзвэл 24 хүн буюу 14 хувь нь гэр бүлийн насанд хүрээгүй хүүхдээ ажилд дайчилдаг гэж хариулсан юм.

Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай онцлон сануулсан байдаг ч бичил уурхайн үйл ажиллагаанд хүүхдийг хүнд хүчир ажилд хөдөлмөрлүүлэх байдал түгээмэл байгааг тухайн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй сумын Засаг дарга анхаарах шаардлагатай байна. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.1-д 18 нас хүрээгүй иргэнийг ажиллуулахыг хориглосон хэдий ч нөхөрлөлийн гишүүн бичил уурхайчид гол төлөв гэр бүлээрээ уг ажлыг эрхэлдэг, улмаар тэдгээрийн хүүхдүүд энэ ажилд давхар дайчлагддаг байдлыг таслан зогсоох шаардлагатай байна.


ХАМО иргэд болон бичил уурхай эрхлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдах байдал харилцан адилгүй байна.

“Та эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж чаддаг уу? гэсэн асуултад иргэд доорхи хариултыг өгсөн байна.



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх, гар аргаар ашигт малтмал олборлоход тулгарч буй хамгийн том бэрхшээл юу байна гэсэн нээлттэй асуултад агаарын бохирдол, тоосжилт ихэссэн нь эрүүл мэндэд хамгийн их хортой байна гэж хариулсан ба мөн газрын хөрснийэвдрэл ихэссэн, архидалт, тамхидалт газар авсан, хүүхдийн сурлага, хүмүүжилд муугаар нөлөөлж байна гэсэн хариултыг олон хүн өгчээ.

Иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх тал дээр орон нутгийн удирдлагын явуулж буй үйл ажиллагаанд ямар үнэлэлт өгөх вэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон ХАМО болон бичил уурхай эрхлэгч иргэд доорхи хариултыг өгсөн байна. Үүнд:



Мөн орон нутгийн удирдлагын зүгээс иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахдаа саналыг нь авч байсан эсэхийг лавлахад 102 хүн санал асуулгад оролцсоны 39 нь Тийм гэж хариулсан бол үлдсэн 63 нь Үгүй гэсэн хариултыг сонгожээ. Мэдээллийн илт тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасанчлан нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон

нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах ажил хийгдэхгүй байгаа нь ХЭҮК-ыг орон нутагт ажиллаж байх үед тогтоогдсон болно.

Түүнчлэн ХАМО иргэд төдийгүй бичил уурхай эрхлэгчид өөрсдийнх нь ажиллаж, олборлолт явуулж буй талбайн ашигт малтмалын нөөцийн талаарх мэдлэг огт байхгүй бөгөөд хүний ам дамжсан яриа, эх сурвалж нь баталгаагүй мэдээлэл дээр үндэслэн гарц сайтай байж магадгүй гэсэн газруудад нүх ухаж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгаа, мониторингийн ажлын үр дүнг үндэслэн бичил уурхайн үйл ажиллагаанд хүний эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр сумдын Засаг дарга нар болон ХАМО иргэд, бичил уурхай эрхлэгчдэд дараах зөвлөмжийг өгч байна.

Сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. Бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орох хүсэлт гаргасан бичил уурхайчидтай гэрээ байгуулж ажилуулах үйл ажиллагаа туйлын хангалтгүй байна. Цаашид ХАМО иргэдийг албан ёсны болгох нь хүний эрхийн зөрчлийг бууруулах ач холбогдолтой болохыг төрийн албан хаагчдад ойлгуулах нөлөөллийн ажлыг үе шаттай үргэлжлүүлэн зохион байгуулах шаардлагатай байна. Зарим сумдад ХАМО иргэд цөөнгүй тоогоор цуглан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр иргэдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг хэрэгжүүлж ажиллах, орон нутгийн тусгай хэрэгцээнд тодорхой газрыг сонгон авч ашиглуулах;
2. Сонгон авсан сумдад ажиллах үед бичил уурхайн журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй албан хаагчдын хувийн шинжтэй хүсэл сонирхол, хандлагаас хамаарч журмын хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь тогтоогдсон болно. Иймд журам батлагдаад тодорхой хугацаа өнгөрсөн төдийгүй уг журмыг бүрэн хэрэгжүүлэх явдал удааширч байгаад дүгнэлт хийж, орон нутгийн иргэдэд бичил уурхайн холбогдолтой хууль тогтоомжийг таниулах, сурталчлах, сайн түршлагыг түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагаа бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах;
3. Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын холбогдох заалтыг үндэслэн АМГ-ын даргын 2011 оны 153 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай” тухай батлагдсан загвараар нөхөрлөлийн гишүүдтэй гэрээ байгуулж хэвших;
4. Нөхөрлөлийн олборлолт явуулсан талбайд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тооцож, зохих мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;
5. Бичил уурхайн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар бичил уурхайчдад тогтмол сургалт, танилцуулга хийж байх шаардлагатай байна. Аюулгүй ажиллагааны наад захын мэдлэг, ойлголтгүй иргэд ашигт малтмал олборлохдоо мөнгөн үс хэрэглэх, тэсэлгээ хийх зэрэг эрсдэлтэй арга замуудыг сонгож байгаа бөгөөд байнгын айдас, түгшүүртэй орчинд ажиллаж хөдөлмөрлөж байгааг анхаарах хэрэгтэй байна. Улмаар ийм нөхцөлд ажиллаж, хөдөлмөрлөж байгаа бичил уурхайчдын хөдөлмөрийн

бүтээмж тэр хэрээр багасч, амь насанд нь эрсдэл учирч байгааг анхааралдаа авах;

6. Тухайн орон нутагт ажлын байр бий болгох замаар ХАМО иргэдийн амьдралд дэмжлэг үзүүлэх;
7. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа насанд хүрээгүй хүүхдүүдийн сурч боловсрох, хөгжих эрхийг нь хангахад чиглэсэн арга хэмжээг бүх шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
8. Орон нутгийн удирдлагаас бичил уурхайн журмын дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж ажилласан талаарх хангалттай тоо мэдээлэл, тайлан, тооцоо хөтөлдөггүй нь хүндрэлтэй байдал үүсгэж байлаа. Иймд үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, холбогдох тоон мэдээллийг цаг тухай бүр дэлгэрэнгүй гаргаж байх шаардлагатай байна;
9. Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан борлуулах тогтолцоо төлөвшиж чадаагүй байна. Монголбанк алтыг худалдан авах боломжтой гэдгээ илэрхийлсэн гэх мэдээлэл байгаа ч хэрхэн, яаж худалдан авах процесс нь тодорхойгүйгээс шалтгаалж хууль бусаар худалдан борлуулахад хүрч байна. Түүнчлэн алтны сорьц тогтоох үйл явц хэт удаашралтай байгаа тул бичил уурхайчид амар хялбар замыг нь сонгож байна гэсэн дүгнэлт хийж болох юм. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдах, худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдана” гэж зохицуулсан нь хангалтгүй байна. Иймд олборлосон ашигт малтмалыг хуулийн дагуу худалдан борлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, журмын 13.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт тавих үүргээ биелүүлж ажиллах;
10. ХАМО иргэд, бичил уурхай эрхлэгчдийг ялгаварлан гадуурхах, төрийн үйлчилгээг хүнд суртал чирэгдэлтэй хүргэх зэрэг зөрчил дутагдал гарч байгаад дүгнэлт хийж, төрийн байгууллагын албан хаагчид, ажилтнуудын үйл ажиллагаанд хүний эрхийн хандлагыг төлөвшүүлэх төлөвлөгөөт ажил зохион байгуулах.

Бичил уурхай эрхлэгчдэд:

1. Олборлолт хийж дууссан талбайд нөхөн сэргээлтийг зохих цаг хугацаанд нь бүрэн хийж орон нутагт хүлээлгэж өгч хэвших, нөхөн сэргээлтийг АМГ-ын даргын 2011 оны 153 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар”-т бүрэн нийцүүлж хийх;

2. Үйл ажиллагаандаа байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн малд хохирол учруулахгүй байх зарчмыг баримталж, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг хэвшүүлэх;
3. Бичил уурхайн ажилтнуудад бичил уурхайн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан зааварчилгаа өгч хэвших;
4. Хуульд заасны дагуу орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварыг орон нутагт тогтмол төлж байх.